

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Баалийн Сүрэн	Дугаар	1038
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Дундговь аймгийн Дэлгэрцогт сум	Төрсөн он	1911
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цахиуртын жас, Дэлгэрийн Чойр	Сүм хийдийн дугаар	ДУДЦ 034 ДУДЦ 039
Одоогийн сүм хийд	Гандантэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	УВ 01
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цахиуртын жас, Дэлгэрийн Чойр

Манай Дундговь аймгийн Дэлгэрцогт сум, Дайчин бэйсийн хошууны Ахын сүмийн (Цахиуртын жас) нутагт Богдоос сунтагтай ганцхан лам байсан юм. Ахын сүмийг Дорждамба дацан гэж нэрлэдэг байсан. Дорждамба дацан их эрт үүссэн түүхтэй. Өндөр Богдын үетэй холбоотой. Цахиуртын жас Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутагт байсан. Хойноо Уст хар толгой гэдэг газартай. Урдаа Цагаан толгой, Адгийн цагаан толгой, Дунд цагаан толгой, Эхэн цагаан толгой гэж байсан.

Дорждамба дуган, Ганжуурын дуган, Сүмийн дуган, Сахиусны дуган гэсэн дөрвөн дугантай байсан. Сүмийн дуганд цагаан сараар томчууд Сандуй, Дэмчиг уншдаг байсан. 70, 80 ламтай. Хүрээнд сууж байсан гэвш нар их ирж Майдар, Хангал энэ тэр их хурдаг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Донжи ладдү цанной мой дэ Минжүүр ловон гэж байсан. Тэр хүнд 7 настай очиж гэдсээ хөөдүүлж, гээгээ авахуулсан. Тэгээд бас манай ах лам халзан Хайдав гэдэг хүн байсан. Нэлээд хэдэн хүүхэд байсан. Баян айлын хүүхэд ч байсан. Хоосон айлын хүүхэд ч байсан. Тэр найман хүүхдийг би ахалж өглөө цай, өдөр цай, орой хоолыг нь идүүлж байсан. Цагаан идээ, будаа, ётон, тос, боов, чихэр гээд янз бүрийн юмыг нь хураагаад нэг авдарт хийчихнэ. Тэгээд үдийн 12 цаг болохоор за миний хүү одоо аяганд нь хийж өг гэнэ. Өөрөө мэдээд л гэнэ. 5, 6 хан минут хэртэй гаргаж барилдуулж завсарлуулаад одоо орооорой гэнэ. Тэгээд л уншлага заалгана. Жаажай ер нь надад их ширүүн байсан. Юм л бол орныхоо араас хулсан ташуур аваад ороолгоно. Тэгээд би Жаажайдаа уйлаад хэлсэн. Жаажай энэ хүний олон хүүхэд байхад аль нь ч адилхан намайг нүд үзүүрлэж байх юм гээд хэллээ. Тийм ээ чамайг нүд үзүүрлэлгүй яхав. Ах дүү улс. Би эжийгийн чинь ах нь. Чамайг хүний дайтай хүн болгох гэж байгаа юм. Энэ баячуудын чинь хүүхэд нэг ташуураар ороолгочихвол шөнө нь яваад айлын нохойд бариулах юм уу, харанхуй шөнө нүдгүй шуурганд явж байж хөлдөж үхнэ. Тэгвэл Жаажай нь шоронд орно. Харин чи бол тэгэхгүй гэж хэлж байсан юм. Өдөр завсарлаж орж ирээд л номоо заалга гэнэ. Заалгасан номоо Жамбалцанжидаас эхлээд Ламаадан гэдгийг чинь унтахаас өмнө мичид голлоод ирэхийн алдад уншуулаад 21 мөргүүлнэ. Манзушир бурхан гэдэг чинь гурван ертөнцийн харанхуйг арилгана гэсэн тийм айлдвартай юм гэсэн гэж хэлдэг байсан. Бид Жаажай дээр Цогчэнг дуусгаад Магтаал эхлээд, Магтаалаа дуусгачихаад хавар цагаан сараар Магтаал хурахлаар голын мөрний тэнд давхар мөрөнд хурна. Магтаал уншиж чадахгүй байгаа хүнд гэсгүй жавдангийн уранхайнаас эсгий авч зуулгаад энэнээс хойш цээжээр уншиж сур, чи яагаад сурдаггүй юм бэ? гээд л. Тэгж л суралцаж байсан юм даа.

Манайх Очирваань сахиустай. Очирваань, Гомбо, Чойжоо, Лхам, Намсрай, Цамба, Дамдин гэнэ. Намайг манай ловон багш миний хүү цанидаа л сайн үзээрэй гэж байсан юм. Дүнгийн багш гэж бас цанидтай, чойртой сүрхий хүн байсан. Тэр бүгдийн л ач гавьяа. Намайг 18 нас хүрэхэд Зава багш миний хүү хадгаар ороорой гэж аав ээжид үүрэг өгчихөөд би чойрт орсон. Чойрт суугаад 3 сар гаруй болж байтал сумаас бүртгэл явагдсан. Урьд чинь эхээс ганц хүүхэд бол хар болох ёстой байсан. Хоёр хүүхэд бол нэг нь лам нэг нь хар. Гурван хүүхэд бол хоёр нь хар нэг нь лам болох ёстой байсан юм.

Манайд хоёр хувилгаан байсан юм. Ганжуур жасын дээр үеийн хамбын хувилгаан гэж байсан.

Манай хийдийн гол сахиус нь Лхам байсан. Лхам сахиус биеэрээ ирсэн. Зуны эхэн сард Дагий Жалваан гэж хурдаг. Шунхан Ганжууртай байсан. Дагий Жалваан, Гомбоо тахиад байж байсан чинь ногоон дээлтэй, улаан алчуураар толгойгоо боосон гоо үзэсгэлэнтэй охин орж ирсэн. Идээ цайгаа өгсөн. Танайх чинь Дагий Жалваан хуруулж байгаа юм уу гэсэн. Тийм ээ Дагий Жалваан, Гомбо сахиусаа хурж, Шунхан Ганжуураа хуруулж байна гэсэн чинь гараад л явчихсан. Хойноос нь гарсан чинь олдоогүй.

Тэгсэн нэг өвгөн хонь хариулаад явж байсан цагаан морьтой, ногоон дээлтэй, улаан алчууртай, алчуур нь хийсээд Лондлын хөтлөөр давсан гэж ярьсан. Шинэ дуганаа барьчихаад шалаа тавиагүй байж байтал түүн дээгүүр Лхам сахиусны морины мөр гарсан гэж байгаа. Айхтар өвчин гарахлаар зэрэг Лхам гандаг цоггийг уншаад дардаг байсан юм. Нохой баахан юм хөөгөөд л гүйчихнэ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дээр үедээ ловон багш хамба нь байсан. Төвд гуай, Лүнгийн багш гэдэг хүн байсан. Халзан Хайдав гэж манай ах гэсгүй байсан. Шоорон Пунцаг гэдэг хүн гэсгүй байсан. Хялар Нанжид гэж хүүхдийг ер хайрладаггүй хүн гэсгүй байсан. Бойтог Дашням гэдэг хүн гэсгүй байсан. Хамгийн сүүлд хүнхэр Банзрагч гэдэг хүн байсан. Ичинхорлоо гэж сайхан унзад байсан. Дугаа унзад гэж байсан.

Өглөө цогчэнтэй. Магтаалыг хавар шинийн 3-аас эхэлж хурна. Жисааны нэг хүнтэй. Шинийн 8-д Ганжуур хурна. 120 боть шунхан Ганжууртай байсан. Майдарыг намрын адаг сарын 15-нд эргэнэ. Жамбын чогууны адаг сарын 14-нд хурна. Ингэхэд Эрдэнэ ламын жасаас ирж очилцдог ах дүүгийн холбоо харилцаатай байсан. Майдар эргэхэд хүүхнүүд чинь шунхан Ганжуурыг мөрөвчилчихөөд Майдарын дөрвөн гороогоор эргээд буян хийж байсан юм. Сарын дүйчэнгийн хурал гэж байгаагүй. Богд ламын дүйчэн өдрөөр цогчэн, магтаал хурна. Нүгнээтэй байсан. Ер өдөр бүгд сахина. Гэхдээ өдөр бүгддээ жисааны хүн л хийнэ. Бусад нь бол чөлөөтэй. 29 болохлоор 28-ны орой хүрч ирээд хурна. Хавар магтаал унших болохоор 10 хэдэн гэж хүрч ирээд л 5 хоног магтаалаа уншина. Хайлантай. Цагаан сарын 15 хоногийн Чонпрүлжонаг гүйцэд хурна. 29-нд сор зална. Лхамын дордов хурдаг байсан. Майдраа эргэж ирчихээд хурна. Дордовт балин гэж мундаг юм байна шүү дээ. Тэр дотор мөнгөн тойг хийдэг байсан. Тэр тойг одоо бий л байх. Лувсанжамба (нас барсан) байж байгаа гэж байсан. Арай л хүний гараар орчихоогүй байх. Лүнгийн багш, гэцэл багш нар Зава багшид та энийг нэг цэгцлээд, томруулаад өгөөч гэсэнд “Пээ над шиг хүн гар хүрэх юм биш. Би зүгээр бүрхан тахилыг нь цэгцэлж өгье гээд” янзалж өгсөн юм гэнэ лээ. Манайд чинь Гүлийг харанхуйд уншина. Гаднаас муу муухай юм оруулахгүй гэж. Манай Цахиуртад мөнгөн бишгүүр, хүрэл хэнгэрэг байсан. Ер нь их нарийн дэг дэглэмтэй газар байсан. Уншлагын газар байсан. Одоо тэр буурин дээр нь нэг дуган бий. Лувсанжамба сэргээсэн.

Цахиуртын жасыг хаагдах үед нь Лувсанжамба байсан. Хүнхэр Банзрагч гэдэг хүн байсан. Хүнхэр Банзар гэдэг хүн гэсгүй хүн байсан. Тангад гэлэн гуай гэдэг хүн байсан. Гэцэл багш таалал төгсчихсөн байсан. Лүнгийн багш таалал төгсчихсөн байсан. Тэгээд тэд нар нэг жаал зугаа юм далд хийсэн юм гэнэ лээ. Тэгсэн тэрнийг нь Мухын Совд гэдэг хүн тэнд нь тийм юм бий гэж хэлээд ухуулчихсан юм гэнэ лээ.

Тэгээд би 1926 онд 18 настайгаасаа 30 хэд хүртлээ Зава багшийн Дэлгэрийн Чойрт суусан. Тэнд дом тавьсан.

Дэлгэрийн Чойрт Цогчэн дуган нь зүүн дацантайгаа хамт байсан. Гунгаачлойлин нь тэрнээсээ баруун тийш ганцаараа хөх туйпуугаар барьсан дуган байсан. Таван аймагтай байсан. Хүрээ дэгтэй байсан.

1.Чоймболин

2.Чойжилдашдэлин

3.Жанчивтэгчинлэн

4.Даржаалин

5.Чойнхорлин

Манайх Даржаалин аймаг байсан. Манай Даржаалин аймаг Жамсран их тахидаг. Лхамыг их тахидаг байсан. Хамгийн ядуу нь байсан. Хөх туйпуугаар ганцхан жижигхэн дөрөвхөн мөртэй дуган бариулсан. Манба, Дүйнхор,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гунгаачлойлин дацан хөх туйпуугаар барьсан. Аймгууд бол дан модон дугануудтай. 200 гаран ламтай байсан. Хүрээнээс багшийн шавь нар их ирнэ. Гавжийн дамжаанд сууж байсан. Гунгаачлойлин дацан нь Банчэн игчаатай. Тэр мичин жил гэхэд Чойр дөнгөж байгуулагдаж байсан. Хөх туйпуугаар жүдийн дуганаа барьчихаад байж байтал манай Дайчин бэйсийн ноён их аманцар хүн байсан. Энэ хөх ухнаа хэзээ сэтэрлэх гэж байгаа юм бол доо гэхэд удахгүй ээ удахгүй танд хэлнэ ээ гэж байсан юм гэнэ лээ.

Гол сахиус нь Лхам, арслан унасан Доржжүв байсан. Манай сахиус шанламтай байсан. Манба нь Дамжин сахиустай байсан.

Хадаг, шидүв, жумбарай, лойрог, ог, гом, лам гээд дом тэгээд умсарва, умнянба, сарва гаарамба гээд 10 жил болоод гавжид тушаагдана.

Ог чинь парчин, гом дээр гэлэн болдог байсан. Зава багш биднийг гомд гэлэн болгуулаад тэгээд ямбаа хуваа гэж байсан. Би умсарва хүртэл явсан. Тэгээд манай зиндаа түг авсан. Өглөө цогчэнтэй. Цогчэнгээ тараад нэг манз уугаад тэгээд Дашчоймбэлийн уншлагаа хийнэ. Тэгээд Лодойдавугаа хийнэ. Гунгаачойлинд Цогчэнгээ тараад Шийравнимбо, Жүдээ уншина.

Чойрт хаврын дунд сарын 24-нд Майдар эргэнэ.

Хар болсноос хойш гар үйлдвэрийн артельд ажиллаж байсан. Жолооч болж 1934 оноос цэргийн дарга хошууч Дамбын хороонд байсан. 1934-1939 оны Халх голын дайны жилүүдэд цэргийн дарга Нянтайсүрэнгийн удирдлагын дор цэргийн алба хаасан.